

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 01 дүгээр
сарын 09 ний өдрийн

Дугаар А-2 /06

Улаанбаатар
хот


Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

Нэг. “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дэд хөтөлбөрийн хүрээнд оролцогч банктай гэрээ байгуулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавихыг Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар /Д.Болдбаатар/-т, дэд хөтөлбөрүүдийг гардан хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавихыг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Р.Эрдэнэбүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг улирал тутам “Иргэдийг орон сууцжуулах, ипотекийн зээлийн тогтолцоог бий болгох ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо”, “Монголбанкны Захирлуудын зөвлөл”-д тус тус танилцуулахыг Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Р.Эрдэнэбүрэн/, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба /Д.Ган-Очир/-нд тус тус даалгасугай.



Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын
Сайдын 2013 оны 01 дүгээр сарын 09 ний өдрийн
А-2/06 дугаар хамтарсан тушаалын ХАВСРАЛТ

“БАРИЛГЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ, УЛМААР ОРОН СУУЦНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр¹, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл², Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэг талаас Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), нөгөө талаас Монголбанк (хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож энэхүү дэд хөтөлбөрийг батлав.
- 1.2 Энэхүү дэд хөтөлбөрийн зорилго нь орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвортой байлгах, иргэдийн эрүүл, аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл

- 2.1 Орон сууцны үнийн хөөсрөлт бий болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор орон сууцны эрэлт, нийлүүлэлтэд чиглэсэн бодлогын арга хэмжээг цаг хугацааны хувьд харилцан уялдаатай авч хэрэгжүүлнэ. Үүний хүрээнд энэхүү дэд хөтөлбөрийн 2.2-т заасан урьдач нөхцлүүд хангагдсан байна.
- 2.2 Дараах урьдач нөхцөл хангагдах буюу Засгийн газраас орон сууцны барилгын нийлүүлэлтийн хязгаарлалтуудыг арилгах бодлогын арга хэмжээг авч эхэлсэн тохиолдолд Монголбанк БХБЯ-тай хамтран энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.2.1 Улаанбаатар хотыг баруун, зүүн тийш тус бүр 30 км, урагшаа 20 км тэлж, замын төгсгөлийн цэгүүд дээр суурьшлын шинэ бүсүүдийг нээн, тэдгээрийг Улаанбаатар хотын төвтэй холбосон нийт 80 км хурдны авто замыг тавих зураг, төслийг 6 сарын дотор бэлэн болгож, 24 сарын дотор ашиглалтанд оруулах;
 - 2.2.2 Суурьшлын шинэ бүсэд орон сууцны хороолол барих газрын хангамжийг бий болгож, орон сууцны хорооллын газрыг нээлттэй, ил тод эзэмшүүлэх;

1 Орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх; ажилтай, тогтмол орлоготой хүн бүр орон сууцны зээлд хамрагдах бодлогыг хэрэгжүүлж, гэр хорооллыг орон суурьжуулах, дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хот, аймаг, суманд хэрэгжүүлэх;

2 Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлнэ. Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, тэдгээрийг хөрөнгөөр баталгаажсан, Засгийн газрын болон орон нутгийн үнэт цаасны зах зээлд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.

- 2.2.3 Суурьшлын шинэ бүсүүд хүртэл инженерийн дэд бүтэц (дулаан, цахилгаан, цэвэр усны хангамж, бохир ус цэвэршүүлэх байгууламж гэх мэт)-ийг 24 сарын дотор барьж ашиглалтанд оруулах;
- 2.2.4 Барилгын гол нэр төрлийн материалын хангамжийг сайжруулах;
- 2.2.5 Монголбанк, Зам, тээврийн яамны хамтран хэрэгжүүлж буй “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд импортын барилгын материалын тээвэрлэлтийн хязгаарлалтыг арилгаж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- 2.2.6 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.7.7 дахь заалтыг хэрэгжүүлэх;
- 2.2.7 Орон сууцны зориулалттай барилгын эзэмшлийн тархалтын судалгаа, орон сууц худалдах, худалдан авах, түрээслэх үйл ажиллагааны өмчлөл/эзэмшлийн нэрийн шинжилгээг хийж, үл хөдлөх хөрөнгийн татварын зохистой тогтолцоог нэвтрүүлэх;
- 2.2.8 Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн (институциональ) хөрөнгө оруулагчдыг бий болгох эрх зүйн тогтолцоог бий болгож, дэмжлэг үзүүлэх.

2.3 Энэхүү дэд хөтөлбөрийн 2.2-т заасан урьдач нөхцлүүд хангагдсан тохиолдолд 3.1.2-т заасан “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэнэ.

2.4 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.2-т заасан хөтөлбөрийн санхүүжилт нь тэргүүн ээлжинд суурьшлын шинэ бүсүүд дээр баригдах орон сууц, үүний дараа хотын захаас төв рүү чиглэсэн дарааллаар баригдсан орон сууцыг худалдан авах ипотекийн зээлд зориулагдана.

2.5 Энэхүү дэд хөтөлбөрийн 2.2-т заасан урьдач нөхцлүүд цаг хугацааны хувьд зөв дараалалтай, харилцан уялдаатай хэрэгжиж, дэд хөтөлбөр хэрэгжиж дуусах үед суурьшлын шинэ бүс дэх орон сууцны хорооллууд ашиглалтанд орсон байна.

Гурав. Дэд хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг, түүнийг хэрэгжүүлэх арга, хэрэгсэл

3.1 “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр нь дараах хөтөлбөрүүдийг багтаана. Үүнд:

3.1.1 Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын үйлдвэрлэгч, зайлшгүй шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ыг импортлогч аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгож, дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдэд³ дэмжлэг үзүүлэн барилгын материалын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар үнийг тогтворжуулах нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий “Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах” хөтөлбөр;

3.1.2 Ипотекийн хоёрдогч захыг санхүүгийн эх үүсвэрээр хангаж, орон сууцны эрэлтийг дэмжих замаар “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөр.

³ Эдгээр төслийн техник, эдийн засгийн үнэлгээ нь хөндлөнгийн аудит, мониторингийн компаниар хянагдаж, баталгаажсан байна.

3.2 Хэрэгжүүлэх арга, хэрэгсэл:

3.2.1 “Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:

- Барилгын гол нэр төрлийн материал үйлдвэрлэгч, импортлогчдод стандартын шаардлага хангасан бараа, материалын үлдэгдэл, үйлдвэр, тоног төхөөрөмжийг барьцаанд тооцуулан эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх боломжийг олгоно.

3.2.2 “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөрийн хувьд:

- Ипотекийн хоёрдогч захыг хөгжүүлэхийн тулд эхний үе шатанд санхүүгийн эх үүсвэрээр хангах;
- Ипотекийн хоёрдогч захад үйл ажиллагаа явуулах үндсэн санхүүгийн байгууллагыг бодлого зохицуулалтаар дэмжих.

3.3 Хэрэгжүүлэх хугацаа: 3 жил

3.4 Санхүүжилтийн нийт дүн: Дэд хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн нийлбэр байна. Дэд хөтөлбөр тус бүрийн хувьд дараах санхүүжилтийн шугам нээнэ:

· “Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн санхүүжилтийн нийт дүн: 379,000,000,000.00 /Гурван зуун далан есөн тэрбум төгрөг/, үүнээс:

- Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад зориулж 64,000,000,000.00 /Жаран дөрвөн тэрбум төгрөг/;
- Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгахад зориулж 265,000,000,000.00 /Хоёр зуун жаран таван тэрбум төгрөг/;
- Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжихэд зориулж 50,000,000,000.00 /Тавин тэрбум төгрөг/;

· “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөрийн санхүүжилтийн нийт дүн: 800,000,000,000.00 /Найман зуун тэрбум төгрөг/.

3.5 Үр дүн: 1/ Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах суурь тогтолцоо бүрдэнэ. 2/ Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоо бий болно. 3/ Орон сууцны үнэ тогтворжих, дундаж давхаргын орон сууцны хүртээмж нэмэгдэх боломж бүрдэнэ. 4/ Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үнэ тогтворжиж, зардлын шалтгаантай инфляцийн дарамт буурах суурь нөхцөл бүрдэнэ.

3.6 Монголбанкны хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.6.1 Энэхүү дэд хөтөлбөрийн 3-т заасан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжүүлэх арга, хэрэгсэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудлыг БХБЯ-тай хамтран шийдвэрлэнэ.

3.6.2 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн хувьд оролцогч банкны хүсэлтийг хянан, зөвшөөрөл олгож, гэрээ байгуулна.

3.6.3 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн хувьд БХБЯ-наас сонгон шалгаруулсан барилгын гол нэр төрлийн материал үйлдвэрлэгч, зайлшгүй шаардлагатай барилгын материалыг импортлогч аж ахуйн нэгж, дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэгчдэд дараах нөхцөлтэй хөтөлбөрийн санхүүжилтийг оролцогч банкаар дамжуулан олгоно:

- | | |
|---------------------------|---|
| · Зээлийн зориулалт: | 3.1.1-д заасан хөтөлбөрийн санхүүжилт |
| · Зээлийн төрөл: | Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр |
| · Зээлийн хүү: | Монголбанкнаас тогтоосон хүү+оролцогч банкны хүүний маржины дээд хязгаар |
| · Зээлийн эрхийн хугацаа: | 3 хүртэл жил |
| · Зээлийн барьцаа: | Тухайн хөтөлбөрөөс хамаарна (Тухайлбал, бараа, материалын үлдэгдэл болон бусад хөрөнгө) |
| · Үйлчилгээний шимтгэл: | Оролцогч банктай тохиролцсноор |

3.6.4 Оролцогч банктай байгуулсан гэрээндээ тогтмол хяналт тавьж, санхүүжилтийн нэгдсэн мэдээг сар тутам гаргаж, нийтэд мэдээнэ.

3.6.5 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.2-т заасан хөтөлбөрийн хүрээнд ипотекийн хоёрдогч захыг хөгжүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан үнэт цаасыг мөнгөний захад зуучлан борлуулах, мөнгөний бодлогын зорилгод харшлахгүй тохиолдолд худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.7 Барилга, хот байгуулалтын яамны хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.7.1 Энэхүү дэд хөтөлбөрийн 2-т заасан урьдач нөхцлийг хангах арга хэмжээг Засгийн газрын холбогдох яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.7.2 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт болон хөтөлбөрт

хамрагдах барилгын гол нэр төрлийн материалын чанарын стандартыг тус тус тогтооно.

3.7.3 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, дараах нөхцлийг тусгасан гэрээ байгуулна:

- Борлуулалтын үнийг тогтвортой байлгах⁴;
- Стандартын шаардлага хангасан барилгын материалыг нийлүүлэх;
- Зээлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглах;
- Оролцогч банкны зээлийн ерөнхий шаардлагыг хангах;
- Үнийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болзошгүй аливаа эрсдэлийг хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж өөрөө хариуцах;
- Барилгын материалын чанарын стандартад тогтмол хяналт тавьж, үүсэх эрсдэлийг дангаар хариуцахаар хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй тохиролцох;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах.

3.7.4 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.2-г заасан хөтөлбөрийн оролцогч ипотекийн хоёрдогч захын санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулж, түүний ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасанд Засгийн газар баталгаа гаргах ажлыг зохион байгуулна.

3.7.5 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.6.5 болон 4.1-д заасан зорилгоор ЗГҮЦ гаргах зөвшөөрлийг Засгийн газар, УИХ-аас авах ажлыг зохион байгуулна.

3.7.6 Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх төрийн аливаа дэмжлэг нь дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нь орон сууцыг худалдан авах боломжтой байхаар тогтвортой өсөх нөхцлийг бүрдүүлэх;
- Засгийн газраас урьдчилгаа төлбөрт баталгаа гаргах, хүүний зөрүүнд⁵ татаас олгох замаар дундаж орлоготой өрхийн орон сууц худалдан авалтыг дэмжих;
- Засгийн газрын халамжийн бодлогын хүрээнд өөрийн өмчлөлийн орон сууцыг бага орлоготой өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр түрээслэх тогтолцоог нэвтрүүлэх.

3.7.7 Барилгын гол нэр төрлийн материалын нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг тогтмол хангах зохион байгуулалтын ажлыг Засгийн газрын холбогдох яам, байгууллага, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.7.8 Орон сууцны барилгын нийлүүлэлтийн талын бусад хүчин зүйлс (хурдны авто зам, инженерийн дэд бүтэц, орон сууцны газар гэх мэт)-ийг бүрдүүлэх талаар Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн газрын алба болон Засгийн газрын холбогдох яам, байгууллагатай хамтран ажиллаж, ажлын уялдаа холбоог хангана.

⁴ Гадаад, дотоод зах зээлд огцом өөрчлөлт ороогүй нөхцөлд

⁵ Ипотекийн зээлийн зах зээлийн хүү болон хөнгөлөлттэй зээлийн хүүний зөрүү

- 3.7.9 Дэд хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаа (хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид санхүүжилт олгохоос бусад)-ны хэрэгжилтийг зохион байгуулна.
- 3.7.10 Дэд хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд холбогдох байгууллага (Нийслэлийн засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг болон бусад)-тай хамтран тогтмол хяналт тавьж, газар дээрх шалгалт хийнэ.
- 3.7.11 Барилгын гол нэр төрлийн материалын борлуулалтын үнийн мэдээллийг ил тод байлгаж, үнэд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 3.7.12 Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг бүс нутгийн шинжтэй хөгжүүлж, цаг хугацаа, тээвэрлэлтийн зардлыг бууруулах нөхцөл бүрдүүлнэ.

Дөрөв. Монголбанкны чиг үүрэг

- 4.1 Энэхүү дэд хөтөлбөрийн 2.2.1-д заасан урьдач нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийн тодорхой хэсгийг ЗГҮЦ-ыг зуучлан худалдах, худалдан авах замаар санхүүжүүлнэ.
- 4.2 Хуучин орон сууц барьцаалан ипотекийн зээл авах тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.3 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн хувьд оролцогч банкинд олгох зээлийн дээд хэмжээ, Монголбанкнаас тогтоосон хүү болон оролцогч банкны хүүний маржины дээд хязгаарыг⁶ сар тутам тогтоож, зарлана.
- 4.4 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн сонгосон оролцогч банктэй байгуулсан гэрээнд тогтмол хяналт тавьж, санхүүжилтийн нэгдсэн мэдээг сар тутам гаргаж, нийтэд мэдээлнэ.
- 4.5 Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн санхүүжилтийн нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг БХБЯ-тай хамтран гаргана.
- 4.6 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.7.3 дахь заалтын дагуу байгуулах гэрээний төсөлд санал өгөх, байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 4.7 Энэхүү хөтөлбөрийн 3.6.1 заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 1/ БХБЯ-наас мэдээ, мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах, 2/ холбогдох саналаа хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд Монголбанкны саналыг дэмжсэнд тооцож, хэрэгжилтийг хангуулна.

⁶ “Монголбанкнаас тогтоосон хүү” гэж Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах зээлийн хүүг; “Оролцогч банкны хүүний маржины дээд хязгаар” гэж Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах оролцогч банкны нэмэх хүүний дээд хязгаарыг тус тус хэлнэ.

- 4.8 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн хүрээнд оролцогч банкинд олгосон нийт зээлийн дүнг дунд хугацааны Засгийн газрын үнэт цаасаар солино.
- 4.9 Оролцогч банкттай байгуулсан гэрээгээ биелүүлээгүй хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч хуулийн этгээдийг хөтөлбөрөөс хасуулах, хуулийн дагуу арга хэмжээ авах саналыг БХБЯ-нд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 4.10 Барилгын гол нэр төрлийн материалын үнэ, орон сууцны үнийг тогтворжуулах чиглэлээр хэрэгжиж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг БХБЯ-наас авна.
- 4.11 Барилгын материалын нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн үнийн талаарх мэдээллийг тухай бүр БХБЯ-наас авна.
- 4.12 Оролцогч банкнаас ирүүлсэн зээлийн хүсэлт, зээлийн хорооны хурлын шийдвэр, өмнөх зээлийн ашиглалтын тайлан зэрэг баримтыг үндэслэн оролцогч банкинд хөтөлбөрийн зориулалтаар зээл олгоно.
- 4.13 Оролцогч банкнаас хөтөлбөрийн зээлийн ашиглалт болон эргэн төлөлтийн талаарх тайлан мэдээг сар бүр авч, нийтэд мэдээлнэ.
- 4.14 БХБЯ-ны хүсэлтийн дагуу оролцогч банкттай холбоотой асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулна.

Тав. Барилга хот байгуулалтын яамны чиг үүрэг

- 5.1 Энэхүү дэд хөтөлбөрийн 2.2-т заасан урьдач нөхцлүүд, тэдгээрийн уялдааг хангах чиглэлд Засгийн газраас ямар арга хэмжээ авч байгааг сар тутам Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.2 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1-д заасан хөтөлбөрүүдийг Монголбанкттай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.3 Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны хариуцан гүйцэтгэж буй үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн тавьж буй саналыг Монголбанкинд уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 5.4 Монголбанкнаас оролцогч банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавихад төлөөллөө оролцуулна.
- 5.5 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.7.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчийн хуулийн дагуу хариуцлага хүлээх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.6 Барилгын материалын үнэ болон орон сууцны барилгын үнийн хэлбэлзлээс зайлсхийх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

- 5.7 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.1.1-д заасан хөтөлбөрийн хүрээнд дотоодод үйлдвэрлэгдэх, импортлогдох барилгын материалын чанар, стандартад хяналт тавина.
- 5.8 Барилгын материалын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 5.9 Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулж, нийлүүлэлтийн хангамжийг тогтворжуулснаар орон сууцны барилгын үнийг тогтвортой байлгах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 5.10 Энэхүү дэд хөтөлбөрийн 3.7.3 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ Монголбанкнаас санал авч тусгана.
- 5.11 Барилгын гол нэр төрлийн материалын нийлүүлэлтийн хэмжээ, орон сууцны барилгын тоонд гарч буй өөрчлөлтийг тухай бүр бүртгэн нэгтгэж, Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.12 Энэхүү дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг сар бүр нийтэд мэдээлж байна.
- 5.13 Энэхүү дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөхүйц бодлогын шийдвэр гаргахдаа Монголбанктай зөвшилцөнө.
- 5.14 Орон сууц, барилгын гол нэр төрлийн материалын зах зээлийн дараах мэдээллийг ил тод, нээлттэй болгоно:
- Орон сууцны барилгын тоо (байршил болон бусад ангиллаар);
 - Шинэ орон сууцны дундаж хэмжээ, үнийн мэдээлэл;
 - Барилгын материалын нөөц бүрдүүлэх, худалдаалах механизм;
 - Барилгын материалын дотоодын үйлдвэрлэл, импортын хэмжээ (нэр төрөл бүрээр);
 - Барилгын материалын үнийг тухай бүр мэдээлэх.
- 5.15 Засгийн газраас барилгын салбарт авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, түүний хүлээгдэж буй үр дүн, тооцоо үндэслэлийг тухай бүр Монголбанкинд ирүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг сурталчлах

- 6.1 БХБЯ болон Монголбанк хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн хэрэгжилтийг улирал тутам нийтэд мэдээлнэ.

_____ оОо _____